

"ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

"Дарханы дулааны сүлжээ" ХК-ийн Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн хуралдааныг шуурхай зохион байгуулж, хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг оновчтой сонгож, шийдвэр гаргаж хэрэгжүүлэхэд энэхүү журмын гол зорилго оршино.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Үйлдвэрлэл, техникийн зөвлөл /цаашид "зөвлөл" гэнэ/ нь Дарханы дулаан хангамжийн системийн хэвийн ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашигтай, тогтвортой горим боловсруулж мөрдөх, техник технологийн өөрчлөлт шинэчлэлтийн ажлыг удирдан хэрэгжүүлэх, их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийх ажлыг төлөвлөх, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаа шинжилгээ төслийн ажлыг боловсруулж хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой норм норматив, дүрэм журмыг боловсруулж мөрдүүлэх болон бусад шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гаргана.

1.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд дарга – Дэд захирал, ерөнхий инженер, орлогч дарга - Инженерийн албаны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, техникийн албадын дарга нар, төсөв төслийн инженер гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулна.

1.3. Зөвлөлийн хурлын шийдвэр нь "ДДС" ТӨХК-ийн хэмжээнд техникийн шийдлийн дээд шатны шийдвэр болно.

1.4. Зөвлөл нь хуралдааны шийдвэрээ тэмдэглэлийн хэлбэртэй гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох асуудлаар гүйцэтгэх захирлын тушаал гаргуулна.

Хоёр. Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн үүрэг

2.1. Дулаан хангамжийн системийн техникийн хэтийн төлөвийг тодорхойлох, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх техникийн зураг төсөл, тооцоо судалгаанд үнэлэлт, дүгнэлт өгч, компанийн техникийн нэгдсэн бодлогыг тодорхойлж шийдвэр гаргана.

2.2. Алба, хэлтсүүдийн саналыг үндэслэн шугам, тоноглолын их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийх ажлын эзэлхүүнийг хэлэлцэж батална.

2.3. Дарханы дулаан хангамжийн системийн өвөл, зуны гидравлик горимын тооцоо, үндэслэлийг хэлэлцэн шийдвэр гаргана.

2.4. Дулаан хангамжийн ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ТЭЗҮ-ийг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчийг хэмнэлттэй зарцуулах талаар хэтийн бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх техникийн арга хэмжээний тухай шийдвэр гаргана.

2.5. Гадаад орнуудын болон улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, төслүүдтэй холбоотой санал тавих, төслийн даалгавар боловсруулах, техникийн нөхцөл болон төслийг хэрэгжүүлэх явцад гарсан болон гарч болох хүндрэлтэй тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэр гаргана.

2.6. Компанийн өмнө тохиолдож байгаа хүндрэлтэй болон тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн техникийн шийдэл гаргана.



2.7. Дулааны шугам, тоноглолын их засвар, туршилт өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл, техникийн баримт бичгийн бүрдэлтийн талаар хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгнө.

2.8. Компанийн ажилтнууд, ИТА нарын гаргасан шинэ бүтээл, оновчтой саналын материалыг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх ба батлагдсан шинэ бүтээл, оновчтой саналыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх

2.9. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой норм, норматив, дүрэм журмыг хэлэлцэж батална.

2.10. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ханган биелүүлэхэд шаардлагатай материал сэлбэг, тоног төхөөрөмжийн захиалгыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана.

Гурав. Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн эрх

3.1. Зөвлөлийн хариуцах ажлын чиглэлийн дагуу үйлдвэрлэл, техникийн холбогдолтой асуудлаар шаардлагатай баримт материал сэлбэг, зураг төсөл, үндэслэл тооцоог холбогдох ажилтнаар гаргуулах, илтгэл сонсголыг нь зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх;

3.2. Хэлэлцэж буй асуудлын цар хүрээнээс хамаарч салбарын болон орон нутгийн төр, захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллага, хангагч ба хэрэглэгчийн төлөөлөгчдийг зөвлөлийн хуралдаанд урилгаар оролцуулах

3.3. Техник, технологийн шинэчлэлтийн болон дулааны шугам, тоноглолын өргөтгөлийн ажлын техникийн зураг төслийн талаар санал дүгнэлт гаргах

3.4. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой норм, норматив, дүрэм журмыг хэлэлцэн батлах, шаардлагатай хөрөнгө зардлыг гаргуулах

3.5. Инженер техникийн ажилтнуудыг давтан сургах, шинэ дэвшилтэт технологитой танилцуулах, мэргэжилтэй ажилчид бэлтгэх төлөвлөгөө графикийг хэлэлцэн батлах, шаардлагатай хөрөнгө зардлыг гаргуулах

3.6. Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд хурал зөвлөлгөөн, уулзалт семинар зохион явуулах, төлөөлөгч урих болон шаардлагатай материал, техник хэрэгслийн тооцоо, зардлын төсөв гарган гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллах

3.7. Зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тайланг холбогдох ажилтнаар тогтоосон хугацаанд гаргуулж авах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

Дөрөв. Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн хуралдааныг бэлтгэн явуулах

4.1. Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу улиралд нэгээс доошгүй удаа, цаг үеийн хойшлуулшгүй асуудлаар хугацаа харгалзахгүйгээр зарлан хуралдуулна.

4.2. Зөвлөлийн дарга хуралдааныг удирдан явуулна. Зөвлөлийн даргын эзгүйд (овчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай болон томилолтоор гадагш явсан) үед зөвлөлийн орлогч дарга хуралдааныг удирдана.

4.3. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн шийдвэр гаргана.

4.4. Зөвлөлийн хуралдаанд уригдсан хүмүүс зөвлөх эрхтэйгээр оролцоно.

4.5. Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг тэмдэглэлд тодорхой зааж, зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулан баталгаажуулна.

4.6. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг тухайн оны эхний улиралд боловсруулж, зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батална.

4.7. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

4.8. Хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох албадын дарга нарт албан даалгавар хэлбэрээр өгнө.

Тав. Хариуцлага

Зөвлөлийн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан гишүүд, хуралдаанд хэлэлцүүлэх материалаа чанаргүй бэлтгэсэн буюу хугацаа хожимдуулсан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд ирүүлээгүй анжилтанд хариуцлага хүлээлгэн компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу арга хэмжээ авна.